



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 12 сарын 09 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

## ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСЭГ, ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.8, 18.9 дэх хэсэг, 39 дүгээр зүйлийн 39.2.8 дахь заалт, 40 дүгээр зүйлийн 40.7 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР